

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	3
2	Аудитын тайлан .....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	15
	/төгрөгөөр/ .....	15
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	17
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6	Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	21

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ХХААХҮ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/328  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Мал эмнэлгийн ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мал эмнэлгийн ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2 Аудитын тайлан

### 2.1 Оршил

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Д.Түмэндэмбэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлгийн ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Юнистар аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Тэрбиш ахлагчтай аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 102 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна

## **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

## **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Мал эмнэлгийн ерөнхий газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Мал эмнэлгийн ерөнхий газар нь “мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг баталгаажуулах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах замаар мал эмнэлгийн салбарыг оновчтой нэгдсэн бодлогоор хангагч, худалдааны чөлөөт байдлыг дэмжигч байгууллага болно.” гэж эрхэм зорилгоо тодорхойлжээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т “Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эдийн эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангах, хүн амыг зооноз өвчний эрсдэлээс хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлж, хяналт тавина.” гэж заажээ. Мөн Мал эмнэлгийн ерөнхий газрын улсын бүртгэлийн гэрчилгээнд үндсэн үйл ажиллагааны чиглэлийг “мал амьтны эрүүл мэндийг хамгаалах” гэж тодорхойлжээ.

Мал эмнэлгийн ерөнхий газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Мал эмнэлгийн ерөнхий газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн

бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль
- Малын генетик нөөцийн тухай хууль
- Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2018 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Малын генетик нөөцийн тухай хуулиуд хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан УИХ-ын 2018 оны 41 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 186 дугаар тогтоолоор Мал эмнэлэг, үржлийн газрыг Мал эмнэлгийн ерөнхий газар болгож өөрчлөн зохион байгуулсан.

Агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог батлах тухай ХХААХҮ-ийн сайдын 2018 оны А/115 дугаар тушаалаар тус газрыг 44 хүний орон тоотой баталсан байна. Мал эмнэлгийн ерөнхий газар нь Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах газар /11/, Мал эмнэлгийн эрүүл ахуй баталгаажуулалтын газар /8/, Төрийн захиргаа, санхүү удирдлагын газар /16/, Мал эмнэлгийн хяналт, эрсдэлийн үнэлгээний газар /6/ гэсэн бүтэцтэй байна. Аймаг нийслэлд мал эмнэлгийн газар /22/, сум дүүрэгт мал эмнэлгийн тасаг байхаар орон нутгийн бүтэц батлагдсан. 2018 оны төсөвт орон нутгийн Мал эмнэлгийн газрын төсөв батлагдаагүй, аймаг, нийслэлийн ХААГ-т харъяалагдан ажилласан байна.

Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 188 дугаар тогтоолоор “Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори” улсын төсөвт үйлдвэрийн газрыг Мал эмнэлгийн ерөнхий газрын харъяанд ажиллуулах,” Биокомбинат” аж ахуйн тооцоот улсын үйлдвэрийн газар, “Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори” аж ахуйн тооцоот улсын үйлдвэрийн газрыг тус тус татан буулгах, “Биокомбинат” улсын төсөвт үйлдвэрийн газар /УТҮГ/, “Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори” улсын төсөвт үйлдвэрийн газрыг тус тус байгуулж Мал эмнэлгийн ерөнхий газрын харъяанд байгуулах шийдвэр гаргажээ. Дээрхи байгууллагуудыг 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгож татан буулгасан, 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс “Биокомбинат” УТҮГ, “Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори” УТҮГ шинэ бүтцээр ажиллана.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Мал эмнэлгийн ерөнхий газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Мал эмнэлгийн ерөнхий газар нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Санхүүгийн тооцоолох ХХК-ийн “Acolous” санхүүгийн програм хангамж ашигладаг байна.

Мал эмнэлгийн ерөнхий газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Мал эмнэлгийн ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 24,915,811.8 мянган төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 249,158.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс 1,0 хувиар тооцсон нь эрсдэл дунд гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцсон. Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	99,001.0	
2	Албан шаардлага өгсөн	1	4,000.0	
	Дүн	2	103,001.0	

### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

#### 2.8.1.1 Тухайн жилд санхүүгийн тайлангийн аудит хийхэд анхаарах асуудал, баримтлах нэгдсэн бодлого, чиглэл

Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 101/ШШ2017/03372 тоот захирамжаар төрийн албан хаагчийг ажлаас үндэслэлгүй халсаны улмаас ажилгүй байсан хугацааны цалинд 4,000.0 мянган төгрөгийг олгохоор шийдвэрлэсэн. Үүнээс шүүгчийн захирамжинд дурдсаны дагуу нийгмийн даатгалын шимтгэлийг суутгаж 3,719.0 мянган төгрөгийг 2018 оны 5 дугаар сарын 23-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дансанд шилжүүлсэн байна. Төсвөөс төлсөн дээрх 4,000.0 мянган төгрөгийг авлагаар бүртгэж холбогдох буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй байна.

Энэ нь санхүүгийн тайлагналын иж бүрэн байдал, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүйгээс гадна Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д заасан "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д заасан "иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох албан тушаалтнаар төлүүлэх албан шаардлага өгөх

## **2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Мал эмнэлэг, үржлийн газар өөрчлөн зохион байгуулагдаж Мал эмнэлгийн ерөнхий газар болсон. Ерөнхий газрын бүтцэд нийслэл, 21 аймгийн Мал эмнэлгийн газар харьяалагдах болсонтой холбоотойгоор 2019 онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгдсэн санхүүгийн тайлан гарах тул орон нутаг, салбарын санхүүгийн тайланг хамруулан шалгах шаардлагатай. Мөн хандив тусламжаар ирсэн бараа материалыг хянах шаардлагатай байна.

### **2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Мал эмнэлгийн ерөнхий газар чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 28 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 25,457,493.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 25,425,807.1 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна. Төсөв хэтрээгүй батлагдсан төсвийн хүрээнд ажиллажээ.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Мал эмнэлгийн ерөнхий газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Мал эмнэлгийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Мал эмнэлгийн ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан, цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Албан томилолтын талаар**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Албан томилолтын зардлыг ерөнхий газрын даргын тушаалгүй зөвхөн удирдамжийг үндэслэн олгож 90,001.0 мянган төгрөгийг зарцуулсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон холбогдох бусад байгууллагын ажилтны томилолтын зардлыг тухайн байгууллагуудын даргын тушаал шийдвэргүйгээр олгосон байна.

Албан томилолтын зардлыг газрын даргын тушаалгүйгээр гаргаж байгаа нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т “Агентлагийн дарга энэ хууль болон холбогдох бусад хуулиар олгосон бүрэн эрхэд хамаарах асуудлаар тушаал гаргана”, Засгийн газрын 1995 оны 218 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчид нөхөн олговор олгох журмын 5, 10, 11, 12 дугаар заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Дээрх тогтоолын 5 дугаар заалтад “...тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу тодорхой хугацаагаар зохих шийдвэр гарган явуулж ажиллуулсан нөхцөлд албан томилолтын зардал олгоно”, 10 дугаар заалтад “Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчийн байр, зам хоног, уналгын зардлын төсвийг байгууллагын эрх баригч батална”, 11 дүгээр заалтад “Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчид томилолтоор явуулах эрх бүхий албан тушаалтны шийдвэр, батлагдсан зардлын төсвийг нь үндэслэн урьдчилгаа олгоно” гэж тус тус заасан байна.

Албан бичиг хэрэг хөтлөлтийн стандарт MNS 5140:2011-д “Удирдамж гэдэг нь тодорхой ажил хэрэг гүйцэтгэхэд удирдлага болгох зүйлийг тодорхойлсон баримт бичиг” гэж тодорхойлсноос харахад удирдамж нь шийдвэр биш байна.

### 3.1.2 Эрсдэл:

Албан томилолтоор явуулах шийдвэр болон томилолтын төсвийг байгууллагын даргын тушаалаар батлахгүй, зөвхөн удирдамжаар гаргаж байгаа нь дотоод хяналтыг сулруулах эрсдэлтэй.

### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Засгийн газрын 1995 оны 218 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчид нөхөн олговор олгох журмын дагуу, албан томилолтоор явуулах, томилолтын зардал гаргах шийдвэрийг агентлагийн даргын тушаалаар гаргаж байх горимыг холбогдох дотоод журамд тусгаж хэрэгжүүлэх.

### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Байгууллагын өгсөн хариу тайлбарыг В501 маягтад дэлгэрэнгүй тусгасан болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

	/төгрөгөөр/	
Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>867,103,475.06</u></b>	<b><u>3,115,010,809.51</u></b>
<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>АВЛАГА</b>	18,989.18	15,083,549.20
Бусад авлага	18,989.18	15,083,549.20
Байгууллагаас авах авлага	18,989.18	15,083,549.20
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	867,084,485.88	3,099,927,260.31
Хангамжийн материал	867,084,485.88	3,099,927,260.31
Бичиг хэргийн материал	1,378,640.00	8,443,500.00
Аж ахуйн материал	1,939,840.00	146,369,890.00
Түлш, шатах тослох материал	2,490,002.27	6,306,956.74
Бусад хангамжийн материал	861,276,003.61	2,938,806,913.57
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>81,317,881.95</u></b>	<b><u>233,436,657.08</u></b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	81,317,881.95	233,436,657.08
<b>Биет хөрөнгө</b>	81,008,281.95	64,936,657.08
Авто-тээврийн хэрэгсэл	108,036,000.00	108,036,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-92,844,000.00	-108,036,000.00
Машин тоног төхөөрөмж (компьютер)	160,991,037.00	189,038,737.00
Хуримтлагдсан элэгдэл	-119,318,265.11	-155,616,905.33
Тавилга, аж ахуйн эд хогшил	70,618,677.97	115,217,334.97
Хуримтлагдсан элэгдэл	-46,475,167.91	-83,702,509.56
<b>Биет бус хөрөнгө</b>	309,600.00	168,500,000.00
Програм хангамж	523,780,750.00	523,780,750.00
Хуримтлагдсан элэгдэл	-523,471,150.00	-523,780,750.00
Бусад биет бус хөрөнгө	0.00	168,500,000.00
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>948,421,357.01</u></b>	<b><u>3,348,447,466.59</u></b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>948,421,357.01</u></b>	<b><u>3,348,447,466.59</u></b>
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	948,421,357.01	3,348,447,466.59
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	870,951,254.96	870,951,254.96
Өмч: - төрийн	870,951,254.96	870,951,254.96
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	77,287,237.99	2,477,313,347.24
Өмнөх үеийн үр дүн	1,462,026,668.50	77,287,237.66
Тайлант үеийн үр дүн	-1,384,739,430.51	2,400,026,109.58
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	182,864.39	182,864.39
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>948,421,357.01</u></b>	<b><u>3,348,447,466.59</u></b>

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>24,248,472,799.52</b>	<b>27,315,837,937.28</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,687,492,673.52</b>	<b>1,658,418,947.38</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	602,401,198.01	1,658,418,947.38
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	598,572,698.01	1,658,418,947.38
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	604,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	597,968,698.01	1,654,650,812.58
120009	Бусад орлого	3,828,500.00	3,768,134.80
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	2,085,091,475.51	-
122002	Хандив тусламж /гадаад/	2,085,091,475.51	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>21,560,980,126.00</b>	<b>25,657,418,989.90</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	21,512,940,126.00	25,440,586,489.90
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	21,501,450,956.00	25,440,586,489.90
131005	Хөрөнгийн санхүүжилт	11,489,170.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	48,040,000.00	216,832,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	48,040,000.00	216,832,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>25,633,212,230.03</b>	<b>24,915,811,827.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>25,633,212,230.03</b>	<b>24,915,811,827.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>25,622,422,730.03</b>	<b>24,891,319,556.98</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>236,152,394.59</b>	<b>328,123,532.43</b>
210101	Үндсэн цалин	176,629,294.59	259,393,510.43
210102	Нэмэгдэл	32,080,300.00	35,731,903.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,442,800.00	32,998,119.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>24,888,000.00</b>	<b>39,317,380.64</b>
210201	Тэтгэврийн даатгал	15,798,981.74	27,017,979.48
210202	Тэтгэмжийн даатгал	2,070,807.72	2,941,134.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,231,636.10	2,887,412.64
210204	Ажилгүйдлийн даатгал	449,286.33	587,787.58
210205	Эрүүл мэндийн даатгал	4,337,288.11	5,883,066.90
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>2,948,500.00</b>	<b>3,026,000.00</b>
210304	Байрны түрээс	2,948,500.00	3,026,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20,849,785.92</b>	<b>45,663,916.21</b>
210401	Бичиг хэрэг	6,068,140.00	5,754,288.00
210402	Тээвэр, шатахуун	8,516,557.42	31,882,484.71
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,130,910.50	3,787,127.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,134,178.00	4,240,016.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>15,393,164,404.69</b>	<b>15,486,316,928.07</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,393,164,404.69	15,486,316,928.07

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>157,940,950.00</b>	<b>192,858,600.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	152,020,500.00	186,191,700.00
210604	Урсгал засвар	5,920,450.00	6,666,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>92,729,368.31</b>	<b>104,825,071.00</b>
210702	Дотоод албан томилолт	92,729,368.31	104,825,071.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,558,079,992.77</b>	<b>8,624,285,494.58</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,557,269,862.77	8,623,724,878.40
210803	Даатгалын үйлчилгээ	477,730.00	251,616.18
210804	Тээврийн хэрэгслийн татвар	310,400.00	276,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	32,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>135,669,333.75</b>	<b>66,902,634.05</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	102,242,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	33,434,820.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,427,333.75	33,467,814.05
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,789,500.00</b>	<b>24,492,270.72</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>10,777,000.00</b>	<b>5,991,383.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,677,000.00	5,991,383.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,100,000.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>12,500.00</b>	<b>18,500,887.72</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,500.00	18,500,887.72
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>(1,384,739,430.51)</u></b>	<b><u>2,400,026,109.58</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(1,384,739,430.51)</u></b>	<b><u>2,400,026,109.58</u></b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>21,555,469,456.00</u></b>	<b><u>25,676,318,096.90</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,978,500.00</b>	<b>18,899,107.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	5,978,500.00	18,899,107.00
120001	Хувьцааны ногдол ашиг	-	-
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	2,150,000.00	18,899,107.00
120009	Бусад орлого	3,828,500.00	12,225,665.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>21,549,490,956.00</b>	<b>25,657,418,989.90</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	21,501,450,956.00	25,440,586,489.90
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	21,501,450,956.00	25,440,586,489.90
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	48,040,000.00	216,832,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	48,040,000.00	216,832,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>21,553,027,456.00</u></b>	<b><u>25,663,291,396.90</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>21,553,027,456.00</b>	<b>25,663,291,396.90</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>21,542,237,956.00</b>	<b>25,623,715,576.98</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>235,971,383.77</b>	<b>328,123,532.43</b>
210101	Үндсэн цалин	176,448,083.77	259,393,510.43
210102	Нэмэгдэл	32,080,500.00	35,731,903.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,442,800.00	32,998,119.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>24,888,000.00</b>	<b>39,317,380.64</b>
210201	Тэтгэврийн даатгал	15,798,981.74	27,017,979.48
210202	Тэтгэмжийн даатгал	2,070,807.72	2,941,134.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,231,636.10	2,887,412.64
210204	Ажилгүйдлийн даатгал	449,286.33	587,787.58
210205	Эрүүл мэндийн даатгал	4,337,288.11	5,883,066.90
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>2,948,500.00</b>	<b>3,026,000.00</b>
210304	Байрны түрээс	2,948,500.00	3,026,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>21,033,508.50</b>	<b>61,477,591.50</b>
210401	Бичиг хэрэг	5,613,900.00	12,466,148.00
210402	Тээвэр, шатахуун	9,075,100.00	38,201,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,130,910.50	4,254,127.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,213,598.00	6,555,866.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>11,344,015,832.96</b>	<b>15,940,494,714.63</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,344,015,832.96	15,934,812,714.63
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>159,684,250.00</b>	<b>193,600,100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	153,763,800.00	157,900,500.00

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	5,920,450.00	35,699,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>94,659,488.00</b>	<b>104,825,071.00</b>
210702	Дотоод албан томилолт	94,659,488.00	104,825,071.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,558,079,992.77</b>	<b>8,904,238,808.40</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,557,269,862.77	8,903,724,878.40
210803	Даатгалын үйлчилгээ	477,730.00	204,930.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	310,400.00	276,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	32,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>100,957,000.00</b>	<b>48,612,378.38</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	95,957,000.00	15,177,558.38
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	33,434,820.00
<b>211</b>	<b>ХҮҮ</b>	-	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,789,500.00</b>	<b>39,575,819.92</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	10,777,000.00	5,991,383.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,677,000.00	5,991,383.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,100,000.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	12,500.00	18,500,887.72
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,500.00	18,500,887.72
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	15,083,549.20
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	15,083,549.20
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>2,442,000.00</u></b>	<b><u>13,026,700.00</u></b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	-	-
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>2,442,000.00</b>	<b>13,026,700.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,442,000.00</b>	<b>13,026,700.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	2,442,000.00	13,026,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,442,000.00	13,026,700.00
<b>2260</b>	<b>Гадаад эх үүсвэрээр</b>	-	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-2,442,000.00</u></b>	<b><u>-13,026,700.00</u></b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
----	---	---	---

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	870,951,254.96	182,864.39	1,462,026,668.50	2,333,160,787.85
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-0.33	-0.33
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>870,951,254.96</b>	<b>182,864.39</b>	<b>1,462,026,668.17</b>	<b>2,333,160,787.52</b>
Тайлант үеийн үр дүн	-	-	1,384,739,430.51	1,384,739,430.51
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>870,951,254.96</b>	<b>182,864.39</b>	<b>77,287,237.66</b>	<b>948,421,357.01</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>870,951,254.96</b>	<b>182,864.39</b>	<b>77,287,237.66</b>	<b>948,421,357.01</b>
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,400,026,109.58	2,400,026,109.58
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>870,951,254.96</b>	<b>182,864.39</b>	<b>2,477,313,347.24</b>	<b>3,348,447,466.59</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	хэмнэлт (-) хэтрэлт (+)	хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>25,457,493,000.00</b>	<b>25,425,807,100.80</b>	<b>-31,685,899.20</b>	<b>99.88</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>25,457,493,000.00</b>	<b>25,425,807,100.80</b>	<b>-31,685,899.20</b>	<b>99.88</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>25,451,493,000.00</b>	<b>25,419,815,717.80</b>	<b>-31,677,282.20</b>	<b>99.88</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>338,146,400.00</b>	<b>328,123,532.43</b>	<b>-10,022,867.57</b>	<b>97.04</b>
Үндсэн цалин	261,038,800.00	259,393,510.43	-1,645,289.57	99.37
Нэмэгдэл	38,744,100.00	35,731,903.00	-3,012,197.00	92.23
Унаа хоолны хөнгөлөлт	38,363,500.00	32,998,119.00	-5,365,381.00	86.01
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>42,270,600.00</b>	<b>39,317,380.64</b>	<b>-2,953,219.36</b>	<b>93.01</b>
Тэтгэврийн даатгал	32,995,300.00	27,017,979.48	-5,977,320.52	81.88
Тэтгэмжийн даатгал	2,318,900.00	2,941,134.04	622,234.04	126.83
ҮОМШӨ-ний даатгал	1,855,100.00	2,887,412.64	1,032,312.64	155.65
Ажилгүйдлийн даатгал	463,700.00	587,787.58	124,087.58	126.76
Эрүүл мэндийн даатгал	4,637,600.00	5,883,066.90	1,245,466.90	126.86
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>3,029,400.00</b>	<b>3,026,000.00</b>	<b>-3,400.00</b>	<b>99.89</b>
Байрны түрээс	3,029,400.00	3,026,000.00	-3,400.00	99.89
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>35,328,900.00</b>	<b>35,182,141.50</b>	<b>-146,758.50</b>	<b>99.58</b>
Бичиг хэрэг	10,744,100.00	12,466,148.00	1,722,048.00	116.03
Тээвэр, шатахуун	11,906,600.00	11,906,000.00	-600.00	99.99
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,435,600.00	4,254,127.50	-2,181,472.50	66.10
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,242,600.00	6,555,866.00	313,266.00	105.02
<b>Нормативт зардал</b>	<b>15,945,808,600.00</b>	<b>15,940,494,664.63</b>	<b>-5,313,935.37</b>	<b>99.97</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,940,108,600.00	15,934,812,664.63	-5,295,935.37	99.97
Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,700,000.00	5,682,000.00	-18,000.00	99.68
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>206,696,800.00</b>	<b>206,626,800.00</b>	<b>-70,000.00</b>	<b>99.97</b>
Багаж, техник, хэрэгсэл	170,997,200.00	170,927,200.00	-70,000.00	99.96
Урсгал засвар	35,699,600.00	35,699,600.00	-	100.00
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>90,339,300.00</b>	<b>90,001,571.00</b>	<b>-337,729.00</b>	<b>99.63</b>
Дотоод албан томилолт	90,339,300.00	90,001,571.00	-337,729.00	99.63

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,789,873,000.00</b>	<b>8,777,043,627.60</b>	<b>-12,829,372.40</b>	<b>99.85</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,789,359,700.00	8,776,529,697.60	-12,830,002.40	99.85
Даатгалын үйлчилгээ	205,000.00	204,930.00	-70.00	99.97
Тээврийн хэрэгслийн татвар	275,600.00	276,300.00	700.00	100.25
Тээврийн хэрэгслийн оношлогоо	32,700.00	32,700.00	0.00	100.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,000,000.00</b>	<b>5,991,383.00</b>	<b>-8,617.00</b>	<b>99.86</b>
Бусад урсгал шилжүүлэг	6,000,000.00	5,991,383.00	-8,617.00	99.86
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,000,000.00	5,991,383.00	-8,617.00	99.86
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>25,457,493,000.00</b>	<b>25,422,085,602.18</b>	<b>-35,407,397.82</b>	<b>99.86</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>25,457,493,000.00</b>	<b>25,422,085,602.18</b>	<b>-35,407,397.82</b>	<b>99.86</b>
Улсын төсвөөс санхүүжих	25,457,493,000.00	25,422,085,602.18	-35,407,397.82	99.86
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>44</b>	<b>31</b>	<b>-13</b>	<b>70.45</b>
Удирдах ажилтан	7	5	-2	71.43
Гүйцэтгэх ажилтан	35	25	-10	71.43
Үйлчлэх ажилтан	2	1	-1	50.00

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>201,748,950.80</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>201,748,950.80</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>201,748,950.80</b>
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>26,295,450.00</b>
Тээвэр, шатахуун	26,295,450.00
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>14,823,500.00</b>
Дотоод албан томилолт	14,823,500.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>127,195,180.80</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	127,195,180.80
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>33,434,820.00</b>
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	33,434,820.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>216,832,500.00</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>216,832,500.00</b>
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	216,832,500.00

## 5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.02.20	Аудитын нэр:	Мал эмнэлгийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын	Аудитын код:
Шалгагдсан байгууллагын нэр:	Мал эмнэлгийн ерөнхий газар			САГ-2019/157/СТА-ТШЗ
				Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Албан томилолтын зардлыг ерөнхий газрын даргын тушаалгүй зөвхөн удирдамжийг үндэслэн олгосон. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон холбогдох бусад байгууллагын ажилтны томилолтын зардлыг тухайн байгууллагуудын даргын тушаал шийдвэргүйгээр олгосон байна.	90,001.0	Зөвлөмж өгөх	Дарга	Д.Түмэндэмбэрэл
2	Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2017 оны 10 сарын 26-ны өдрийн 101/ШШ2017/03372 тоот захирамжаар төрийн албан хаагчийг ажлаас үндэслэлгүй халсны улмаас ажилгүй байсан хугацааны цалинг олгохоор шийдвэрлэсэний дагуу тухайн иргэнд учирсан 4,000.0 мянган төгрөгийн хохирлыг 2018 онд барагдуулсан. Албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас байгууллагад учирсан 4,000.0 мянган төгрөгийн хохирлыг авлагаар бүртгэж, холбогдох этгээдээс нэхэмжилж барагдуулаагүй байна	4,000.0	Албан шаардлага өгөх	Шийдвэр гаргах үеийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Д.Батцэнгэл
	<b>Дүн</b>	<b>94,001.0</b>			



